



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/36

Төгөл

Цалинг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.1, 57.2.2, 57.2.4 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1 дэх заалт, Төрийн албаны болон нууцын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Улсын их хурлын 2007 оны Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай 73 дугаар тогтоол, Улсын их хурлын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн Төрийн захиргааны албан тушаалын 21 дүгээр тогтоол, Улсын их хурлын байнгын хорооны 2012 оны Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон, хөрөнгө мэдүүлгийн маягт, түүнийг бүртгэх хянах, хадгалах "Журам батлах тухай" 05 дугаар тогтоол, Засгийн газрын 128 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн улс төрийн албан хаагчдын албан тушаалын цалин нэгдүгээр хавсралтаар, ТЗ албан тушаалын цалин 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн тогтоосугай.

2.Шинэчилсэн үндсэн ба нэмэгдэл цалинг 2024 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс тооцож олгохыг Засаг Даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Т.Намжилсүрэн)-д зөвшөөрсүгэй

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Санхүү албаны дарга (Б.Хишигсүрэн)-д үүрэг болгосугай.

ДАРГА  БАТБАЯР

